| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                     |                           |                    |

|    |   |  |  |
|----|---|--|--|
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |  |  |
|----|---|--|--|

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |              |
|-----------------------|--|-----------------------|--------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл    |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                       |              |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 364929700.00          | 364929700.00 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 364929700.00          | 364929700.00 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 355429700.00          | 355429700.00 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 248519700.00          | 248924700.00 |
| 210101                | Үндсэн цалин   | 176414000.00          | 176819000.00 |
| 210102                | Нэмэгдэл   | 48067000.00           | 48067000.00  |
| 210105                | Гэрээт ажлын хөлс  | 24038700.00           | 24038700.00  |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 33550200.00           | 35132400.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 23609500.00           | 23609500.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 2485200.00            | 4067400.00   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 1988100.00            | 1988100.00   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 497000.00             | 497000.00    |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 4970400.00            | 4970400.00   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 13180300.00           | 11193100.00  |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 1104800.00            | 1104800.00   |
| 210302                | Түлш, халаалт  | 12075500.00           | 10088300.00  |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 8939100.00            | 8939100.00   |
| 210401                | Бичиг хэрэг  | 2183700.00            | 2183700.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 5619000.00            | 5619000.00   |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1048400.00            | 1048400.00   |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 88000.00              | 88000.00     |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>  | 457000.00             | 457000.00    |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 457000.00             | 457000.00    |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 1135700.00            | 1135700.00   |
| 210604                | Урсгал засвар  | 1135700.00            | 1135700.00   |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>  | 2169400.00            | 2169400.00   |
| 210702                | Дотоод албан томилолт  | 2169400.00            | 2169400.00   |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 17277800.00           | 17277800.00  |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16150400.00           | 16150400.00  |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 302200.00             | 302200.00    |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 90300.00              | 90300.00     |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар   | 178900.00             | 178900.00    |

|             |  |                     |                     |
|-------------|--|---------------------|---------------------|
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                            | 75000.00            | 75000.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                          | 378700.00           | 378700.00           |
| 210807      | Газрын төлбөр  | 37300.00            | 37300.00            |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                   | 65000.00            | 65000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                   | <b>30200500.00</b>  | <b>30200500.00</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 29700500.00         | 29700500.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 500000.00           | 500000.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>9500000.00</b>   | <b>9500000.00</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                            | <b>9500000.00</b>   | <b>9500000.00</b>   |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                  | 9500000.00          | 9500000.00          |
| <b>13</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>364929700.00</b> | <b>364929700.00</b> |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>364929700.00</b> | <b>364929700.00</b> |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                                     | 364929700.00        | 364929700.00        |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                     |                     |
| <b>5</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> |                     |                     |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  | <b>1.00</b>         | <b>1.00</b>         |
| 610001      | Төсвийн байгууллага                                      | 1.00                | 1.00                |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | <b>23.00</b>        | <b>23.00</b>        |
| 620001      | Удирдах ажилтан  | 8.00                | 8.00                |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 7.00                | 7.00                |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 6.00                | 6.00                |
| 620004      | Гэрээт ажилтан   | 2.00                | 2.00                |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                               | <b>23.0</b>         | <b>23.0</b>         |
| 650001      | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                       | 8.00                | 8.00                |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)               | 5.00                | 5.00                |
| 650010      | Гэрээт ажилтан   | 3.00                | 3.00                |
| 650011      | Улс төрийн албан хаагч (УТ)                              | 7.00                | 7.00                |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт  | Гүйцэтгэл         |
|---|-------------------|
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                         |                   |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>1492264.00</b> |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>1492264.00</b> |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 1492264.00        |
| <b>Нормативт зардал</b>   | 0.00              |
| Хоол, хүнс  |                   |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | 1492264.00        |
| Бараа үйлчилгээний бусад зардал   | 1492264.00        |
| <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>0.00</b>       |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг |                   |
| <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>1492264.00</b> |

|   |            |
|---|------------|
| <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 1492264.00 |
| ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |            |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 1492264.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |            |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   |            |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, өглөгийн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Бугат сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан, төрийн бодлого шийдвэр, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хөнгөн шуурхай, ил тод явуулж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газарт 2021 онд эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 311.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.1 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт       | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|----------|
| Б              | 1              | 2               | 3=2-1    |
| Мөнгөн хөрөнгө | 0.00           | 0.00            | 0.00     |
| Авлага         | 14558.1        | 9311.8          | -5246.3  |

|   |                        |                        |                        |
|---|------------------------|------------------------|------------------------|
| Урьдчилгаа  | 0.00                   | 0.00                   | 0.00                   |
| Бараа материал                                    | 750.0                  | 750.0                  | 0.00                   |
| Үндсэн хөрөнгө                                    | 736718.9               | 719882.8               | -16836.1               |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b><u>752027.0</u></b> | <b><u>729944.6</u></b> | <b><u>-22082.4</u></b> |
| Өр төлбөр   | 24946.7                | 24870.2                | -76.4                  |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | <u>727080.3</u>        | <u>705074.4</u>        | <u>166532.7</u>        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b><u>752027.0</u></b> | <b><u>729944.6</u></b> | <b><u>-22082.4</u></b> |

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, авлагын дансны үлдэгдэл 9.3 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны оны эхний ба эцсийн үлдэгдэл 0.7 сая төгрөг ба өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд 19.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 19.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 719.9 сая төгрөг болж 16.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 63.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2021 оны 133 дугаар тогтоолын дагуу 25.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шилжүүлж, 104.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 80.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс үлдэгдэл 24.8 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 8.6 сая, татварын өглөг 16.2 сая төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 705.0 сая төгрөг болж 22.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 22.0 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 429.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 41.1 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 47.1 сая төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус эрүүл мэндийн төвийн 2021 оны анх батлагдсан төсөв 321.2 сая төгрөг, тодотгосон төсөв 364.9 сая төгрөг буюу 43.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 364.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 364.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн 68.2 хувийг цалин, 9.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 3.1 хувийг тогтмол зардал, 2.4 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.3 хувийг эд хогшил худалдан авах, 4.8 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.6 хувийг томилолт, зочны зардал, 8.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 2.6 хувийг урсгал шилжүүлэг зэрэг зардлууд эзэлж байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын тамгын газраас 1.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ. Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 1.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 364.9 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 364.9 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 26.2 сая төгрөгийн 3 гүйлгээ гарсныг мэдээлээгүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал мэдээллээс сар, тухай бүр оруулах мэдээллээс 2020 оны 12 дугаар сарын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллүүд, нийтдээ 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Бугат сумын ЗДТГ-ын 2021.12.13-ний №210 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 42.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн албан шаардлага өгч, 40.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 1.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Бугат сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 364.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 26.2 сая төгрөгийн 3 гүйлгээ гарсныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.

##### 2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

###### 2.1 Илрүүлэлт:

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд гэрэл цахилгаан, шуудан холбоо, интернэт, дотоод албан томилолт, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлын тооцоогоор гарсан нийт 14.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

###### 2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр   | Нийт алдаа, зөрчлийн |             | Үүнээс    |     |               |     |                 |            |          |             |
|-----|---------------------------------------|----------------------|-------------|-----------|-----|---------------|-----|-----------------|------------|----------|-------------|
|     |                                       |                      |             | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |            | Зөвлөмж  |             |
|     |                                       | Тоо                  | Дүн         | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн         |
| 1   | Бугат сумын Засаг даргын тамгын газар | 3                    | 42.0        |           |     |               |     | 1               | 1.5        | 2        | 40.5        |
|     | <b>Нийт дүн</b>                       | <b>3</b>             | <b>42.0</b> |           |     |               |     | <b>1</b>        | <b>1.5</b> | <b>2</b> | <b>40.5</b> |